

Нүүдэлч малчдын суурьших үйл явцын газарзүйн судалгаа

С.Энх-Амгалан, Д.Хишигдорж, Ц.Отгонхүү, П.Цэенханд, Г.Урантамир,
Б.Нацагсүрэн

*Нийгэм эдийн засгийн газарзүйн салбар, ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн
amgalan69@yahoo.com, d_dorjoo86@yahoo.com, tsetvna919@gmail.com*

The geographical study of the rural population's settlement

Abstract

Nowadays, moving from a nomadic lifestyle to a settled lifestyle prevails. The purpose of this study is to define the settlement process of nomadic herders in geographical terms and to determine their forms. In 2016-2018, 420 herder households were randomly selected and questionnaires were surveyed and 3 semi-settlement forms were identified. These include the households live in split in some areas (soum, province center and ulaanbaatar city), the number and distance of traditional mobility decreases and long live on one place and establish new forms of livestock breeding in peri-urban areas will be herder's three semi-settlement. Fully settled for herders who settle in well-developed settlements, solving social issues and main source of livelihoods are not livestock, generate income from other sources. Full settlement is divided into two forms: moving to passenger service along the paved road and moving to urban areas and moving directly into a settled lifestyle. However, settlement patterns are different depending on the territorial differences, the natural zones, and entrepreneurship.

Түлхүүр үг

Rural settlement, herder household, mobility, migration, rural settlement pattern

Оршил

Дэлхий дахинд нүүдлийн буюу хөдөөгийн, суурин буюу хотын, хоторхуу буюу завсрын гэсэн 3 янзын амьдралын хэв маяг байх ба орчин үед нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжих нь давамгайлах [Оюунгэрэл Ж., 2004] болжээ.

Нүүдэлчдын суурьших үйл явц нь нийгэм эдийн засгийн тодорхой нөхцөл шаардах учир улс бүхэнд өөрийн гэсэн онцлог хэлбэр, хугацаатай [Базаргүр Д., Чинбат Б., Шийрэв-Адъяа С., 1990] явагддаг.

Нүүдэлч малчдын суурьшлыг нийгэм эдийн засаг, байгаль ашиглалтын олон асуудлыг хамарсан амьдралын нөхцөлийг сайжруулах үндсэн арга зам гэж ойлгох ба дэд бүтцийн сайтар хөгжилтэй тосгон сууринд суурьшиж, нийгмийн

асуудлаа шийдвэрлэж буйгаар илэрнэ [Шийрэв-Адъяа С., 1999].

Тиймээс нүүдэлч малчдын суурьших үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэхүү судалгааны ажилд ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнд гүйцэтгэсэн "Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа" (2017-2019) суурь судалгааны төслийн зарим үр дүнгээс ашигласан болно.

Нүүдэлч малчдын суурьшлын тухай ойлголт: Манай оронд хот болон хөдөөгийн онцлог, иргэдийн соёл иргэншлийн төлөв, өрхийн аж байдал, амьжиргааны түвшин зэргээр эрс ялгаатай суурин ба нүүдэлч гэсэн хоёр амьдралын хэв маяг байдаг [Цэцэнбилэг Ц., 2016].

Монгол орны нүүдэлч малчдын суурьших үйл явцын судалгааг түүхэн гурван үед хувааж тоймлож болно.

1. Хөдөө аж ахуйн нэгдэлжих хөдөлгөөний өмнөх үед нүүдлийн тоо, зай, хугацаа зэрэг орон зай, цаг хугацааны үзүүлэлтүүдийг байгалийн нөхцөлтэй холбон малчдын суурьшлыг судалжээ. Тухайлбал өвөл, хаврын улиралд нүүх тоо цөөрч байгаа нь суурьшиж байгаагийн нэг илрэл [Лхагважав Н., 1979] бөгөөд Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Төв, Хэнтий аймагт суурьших үйл явц идэвхтэй явагдаж (өвөл-зуны нүүдэлтэй) [Жагварал Н., 1974] байна.
2. Нэгдэлжих хөдөлгөөн үүсч хөгжсөн үеэс мал аж ахуйн байршилт, төрөлжилтийг хөдөө аж ахуйг зохистой эрхлэн хөтлөх системтэй уялдуулан малчдын суурьшлыг ангилсан байна. Тухайлбал малчид хөдөлмөрөө хорших, ээлжлэхээс эхлэн малынхаа бэлчээр нутгийг зөв сонгож тохируулснаар заавал малаа дагаж нүүхгүйгээр цөөн удаа, ойр зайнд нүүж, нэг буурин дээрээ удаан байж, улирлын түр суурьшлыг бий болгож [Шийрэв-Адъяа С., 1999] байгаагаас гадна нэгдэл бүр газар тариалан, барилга, хадлан, туслах үйлдвэр эрхлэх тул малчид тодорхой мэргэжил эзэмшин нэгдлийн төвд бүрэн суурьших [Гунгаадаш Б., 1986] болжээ. Нүүдэлч малчдын суурьшилд шилжиж буй дараагийн хэлбэрт ажиллах хүчний хэрэгцээ шаардлагаар хот суурин газарт шилжиж буй шилжилт орно [Баянтөр М., Гантөмөр Х., 1971].
3. 1990-д оноос хойш хийгдсэн судалгаануудад нүүдэлч малчдын суурьшилд нөлөөлөх байгаль, аж ахуй, нийгмийн хүчин зүйлүүдийг судалжээ. Тухайлбал Нүүдэлч

малчдын хэтийн зорилго нь нийгмийнхээ асуудлыг хотын оршин суугчдаас дутуугүйгээр шийдэх [Базаргүр Д., 2005] явдал бөгөөд нүүдэлчдийг төвлөрсөн суурьшилд шилжүүлэхэд (суурин амьдралд) хөдөөгийн тосгон чухал үүрэгтэй. Тэр нь хүмүүсийг өөртөө татаж, суурьшил үүсгэж, хотжилтыг бий [Шийрэв-Адъяа С., 1999] болгоно. Нүүдэлч малчид нь суурьшихдаа суурин газрыг сонирхох, тэмүүлэх, шилжин очих, уусах гэсэн үе шатуудыг дамжина [Базаргүр Д., 2005]. Зах зээлийн эдийн засагт шилжиж, мал хувийн өмчид шилжсэнээр нүүдэлч малчдын суурьшилд ихээхэн өөрчлөлт гарлаа. Энэ нь малчдын шилжих тэмүүлэлтэй уялдан хот суурин газрын татах хүрээнд амьдралын чанарын төлөө [Оюунгэрэл Ж., 2004] хийгдэж буй шилжилт юм.

Судалгааны аргазүй

Энэхүү судалгааны зорилго нь нүүдэлч малчдын суурьших үйл явцыг газарзүйн үүднээс тодорхойлж, түүний хэлбэрүүдийг тогтооход оршино. Тус судалгааг Монгол улсын нутаг дэвсгэрийн 38 хувийг эзлэх эдийн засгийн Төв болон Зүүн бүсэд явуулав.

Үндэсний Статистикийн Хорооны www.1212.mn сайтаас 1995, 2005, 2015, 2018 онуудын хүн ам, малчдын тоо, 2012, 2017 онуудын нийт болон малчин өрхийн тоог авч ашиглав. Анхдагч мэдээ материалд Үндэсний Статистикийн Хорооны даргын 2013 оны 1/149 тоот тушаалаар баталсан "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ыг ашиглан Excel программ дээр боловсруулалтыг хийлээ.

Хээрийн судалгааг 2016-2018 онуудад аймгийн төв, хатуу хучилттай авто замаас алслагдсан байдал, байгалийн бүс, бүслүүрийг харгалзан сонгосон сумдад явуулав. 6 аймгийн 17 сумаас түүврийн холимог аргаар цуглуулсан малчин 420 өрх, сумын төвийн 200 өрхийн социологийн асуулгаас өөрийн малын тоо, нүүдлийн тоо, зай, сургуулийн насны хүүхдийн тоо, өрх тасрах байдал (нөхөр нь хөдөө бага гэрээр малаа хариулж, эхнэр, хүүхдүүд нь 3 сар ба түүнээс дээш хугацаагаар тусдаа амьдрах), газар өмчлөл гэсэн асуултуудын хариулт тус бүрийг Excel программ дээр хувиар илэрхийлж боловсруулалт хийлээ.

Нүүдэлч малчдын суурьшлын хэлбэр: Нийт хүн амын тоонд нүүдлийн амьдралын хэв маягаар аж төрөгчдийн эзлэх хувь 1995 онд 30.7 хувь, 2005 онд 26.1, 2015 онд 20.7 хувь, 2018 онд 18.7 хувь болж тасралтгүй буурсан нь нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжиж байгааг илтгэнэ.

Нүүдэлч малчдын амьдралын хэв маягийг байгалийн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдээр харьцуулан уламжлалт нүүдлээ хийн аж төрж буй малчид, хагас суурьшиж буй малчид, бүрэн суурьшилд шилжсэн малчид (бүдүүвч 1) гэж ангилав.

Судалгааны үр дүн



Бүдүүвч 1. Малчдын амьдралын хэв маяг

Хээрийн судалгаанд хамрагдсан малчин өрхийн 57.4 хувь нь нүүдэлч малчид байх бөгөөд эдгээр өрх нь жилд 3-аас олон удаа нүүдэллэн мал аж ахуйгаа эрхэлж байв. Байгалийн бүс бүслүүрийн онцлогоос хамаарч нүүдлийн тоо, зай хэлбэлзэлтэй ба ойт хээрийн бүсийн малчид жилд 3.7 удаа,

хээрийн бүсийн малчид 4.4 удаа, говийн бүсийн малчид 3.9 удаа нүүж байна.

Ойт хээрийн болон хээрийн бүсийн малчид өвөл нь уулын өвөр бэл, аманд, зундаа нам талархаг нутагт нутаглана. Зуны улиралд урсгал ус, гол горхи, өвөл нь худаг усыг

бэлчээрийн усан хангамжинд ашиглана. Зуслан өвөлжөөний байршилт нь өндрийн хувьд онцын ялгаагүй, нүүдлийн хүрээ нь жилд 30-50 км-т хүрнэ. Говийн бүсэд задгай тэгш талд зусаж, нам уулс толгодын энгэр, бэл, ухаа гүвээ, уул бартаатай газар өвөлждөг. Өөрөөр хэлбэл сэрүүн газар зусаж, сөл орой тасардаг нутаг намаржин, харьцангуй дулаан нутаг өвөлжинө. Худаг ус, булаг шанд, тойром бүрдийг бараадан ойр зуурын хэсэг бэлчээр, хэдэн худгийн хооронд эргэлдэнэ. Говийн бүсийн малчдын нүүдлийн тоо буурч, нүүдэллэх зай 45 км болж багассан нь байгаль цаг уурын өөрчлөлтөөс улбаалж, горхи, булаг шанд ширгэж, худаг бараадан нүүдэллэх болсонтой холбоотой юм.

Нүүдэлч малчдын хагас суурьшлын хэлбэрүүд: Хагас суурьшил гэдэг нь хот айлын бөөгнөрөл биш бөгөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд малчид байнга эсвэл жилийн ихэнх улиралд суурин амьдралд тэмүүлж буйгаар илэрхийлэгдэх ойлголт бөгөөд судалгаанд хамрагдсан малчин өрхийн 42.6 хувь нь хагас суурьшлын хэлбэрт багтаж байна. Хагас суурьшлыг нүүдлийн тоо зайнаас хамаарсан

малчдын хагас суурьшил, суурин газарт өрх тасран амьдарч буй малчдын хагас суурьшил, хот орчмын бүсийг бүрэн суурьшилд шилжих дамжлага болгон ашиглаж буй малчдын хагас суурьшил гэсэн 3 дэд хэлбэрт хуваав (бүдүүвч 1).

Томоохон амралт сувилал, жуулчны баазын ойролцоо, улсын чанартай хатуу хучилттай авто замын дагуу малчид орлогоо нэмэгдүүлэх зорилгоор нүүдэллэн ирдэг. Үүнээс шалтгаалан уламжлалт нүүдлийн тоо, зай цөөрч, нэг буурин дээрээ удаан сууж байгаагаар малчдын хагас суурьшил илэрч байна. Энэ үйл явц малын тооноос ихээхэн хамаарна. Малчин өрхийн малын тоо толгой багасах тутам жилд нүүх нүүдлийн тоо цөөрч буй зүй тогтол илэрлээ. Тухайлбал судалгаанд хамрагдсан 200 хүртэл малтай өрхийн 17.6 хувь нь огт нүүдэггүй бэлчээрээ сэлгэн ашигладаггүй бол 1001-ээс олон малтай өрхийн 47.7 хувь нь жилд 4-өөс олон удаа нүүдэллэж (хүснэгт 1) байна. Цөөн буюу 200 хүртэл толгой малтай өрхүүд уламжлалт гэр сууцандаа нүүдэл хийхгүй жилийн 2-3 улирал (жилийн V-XI сард) суурьшиж байна.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан өрхийн нүүдлийн давтамж, малын бүлэглэлтээр

Малын тооны бүлэглэлт	Нүүдлийн тоо								Бүгд
	Огт нүүдэггүй		1-2 удаа		3-4 удаа		4-өөс дээш		
	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	Өрхийн тоо	Эзлэх хувь	
200 хүртэл	13	17.6	16	21.6	33	47.3	10	13.5	72
201-500	4	3.1	30	23.6	53	43.3	38	29.9	125
501-1000	5	3.5	23	16.3	71	51.8	40	28.4	139
1001-ээс олон	3	3.5	8	9.3	32	39.5	41	47.7	84
Бүгд	25	5.8	77	18	189	46	129	30.1	420

Эх сурвалж: *Хээрийн судалгааны материал, 2016-2018*

Нийгэм эдийн засгийн шалтгааны улмаас сумын төв, аймгийн төв, Улаанбаатарт малчид өрх тасран амьдарч буйгаар малчдын хагас суурьшил илэрнэ. Тухайлбал судалгаанд хамрагдсан малчин өрхийн

22.1 хувь (93 өрх) нь өрх тасран амьдрах (хүснэгт 2) ба үүний 64.5 хувь (60 өрх) нь хүүхдүүдээ боловсрол эзэмшүүлэх шалтгаантай байна.

Хүснэгт 2. Өрх тасрах байдал

Сургуулийн насны хүүхэдтэй эсэх	Асуулга авсан өрхийн тоо	Өрх тасрах байдал			
		Тийм	Эзлэх хувь	Үгүй	Эзлэх хувь
Тийм	200	68	34	132	66
Үгүй	220	25	11.4	195	88.6
Бүгд	420	93	22.1	327	77.9

Эх сурвалж: *Хээрийн судалгааны материал, 2016-2018*

2008-2009 оны хичээлийн жилээс 6 настнууд ерөнхий боловсролын сургуульд элсэх болсноор бага насны хүүхэдтэй малчин өрхүүд илүү өрх тасарч байна. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 2-р багийн малчин өрхийн 42 хувь нь (21 өрх) ам бүл 1-ээр тоологдож байна. Эдгээр малчдын 52.4 хувь (11 өрх) нь гэр бүлтэй ба эхнэр, хүүхдүүд нь Говьсүмбэр аймгийн Баянтал, Сүмбэр суманд бүртгэлтэй байна. Нүүдэлч малчид өрх тасарч амьдарснаар эхнэр хүүхдээ эргэх, ирж очиход дөхөм байх үүднээс суурин газрын ойр нутаглах болжээ.

Гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулах зорилгоор сум орон нутгийн захиргаанаас сумын төвд малчдад гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг

эрчимжүүлсэн нь малчдын суурьшилд шилжих нэг шалтгаан болж байна. Тухайлбал судалгааны нийт өрхийн 38.8 хувь (163 өрх) нь суурин газарт газар өмчилж, өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй болжээ.

Хөдөөгийн малчид бүх малаа зарж дуусган гэрээ ачаад аймгийн төв, нийслэл Улаанбаатарт суурьших нь бараг байхгүй, малтайгаа хот орчмын бүсэд шилжин ирж, тухайн нутгийг дамжлага болгож байна. Малчин өрхүүд нь хоорондоо малаа ээлжлэн отроор эрхлэх, эсвэл цөөн малтай малчинд хөлсөөр хариулгах зэрэг мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрийг үүсгэж байна. Тэд мал аж ахуйн салбараас өрхийн орлогоо бүрдүүлэх нь улам багасаж байгаа нь бүрэн суурьшилд шилжихийн өмнөх үе болж байна. Тухайлбал аймгийн төвийн хүчтэй үйлчлэх зайд (40 хүртэл км) малчин өрхийн тооны өсөлт судалгаа явуулсан нутгийн өсөлт (24.4 хувь)-өөс 2 дахин их (44.6 хувь) (хүснэгт 3) байх бөгөөд малчин өрхийн нийт өрхөд эзлэх хувийн жин нэмэгдэж байна.

Хүснэгт 3. Аймгийн төвийн алслалтаас хамаарсан малчин өрхийн тооны өөрчлөлт

Аймгийн төвөөс алслагдсан зай	Сумын тоо	Малчин өрхийн тооны өөрчлөлт, (2012/2017 он харьцуулсан %)	Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь	
			2012	2017
Аймгийн төв	9	40.2	4.9	5.7
40 хүртэл км	10	44.6	17.3	30.8
41-80 км	17	17.6	41.6	46.1
81-120 км	25	24.7	40.9	46.3
121-ээс дээш км	64	21.6	32.1	35.7
Бүгд	125	24.4	22.8	25.5

Эх сурвалж: www.1212.mn


Нүүдэлч малчдын бүрэн суурьшлын хэлбэрүүд: Энэхүү суурьшил нь дэд бүтэц сайн хөгжсөн суурин газарт суурьшиж, нийгмийн асуудлаа шийдвэрлэхээс гадна өрхийн орлого нь мал аж ахуй байхаа больж, бусад салбараас бүрдүүлж буйгаар илрэх

бөгөөд суурин газарт амьдарч буй малчдын бүрэн суурьшил, авто замын дагуу үйлчилгээний үүрэгтэй сууринд амьдарч буй малчдын бүрэн суурьшил гэж ангилав (бүдүүвч 1).

Малчин өрхүүд орлогын өөр эх үүсвэр хайн хатуу хучилттай авто зам

дагуух үйлчилгээний цэгт хүн амын бөөгнөрлийг үүсгэнэ. Үйлчилгээний цэгүүдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа ба газарзүйн зохистой байршилтай нь бусдаас илүү томорч, сумын төвийн хэмжээнд дүйцэхүйц болж, үйлчилгээний үүргүүд нь төрөлжиж байна. Малчин өрхийн эхнэр, хүүхдүүд нь замын дагуу бүүж, гуанз ажиллуулж байхад нөхөр нь малаа хариулж, мах сүүгээ гуанзандаа нийлүүлнэ. Энэ айл

мөнгөтэй болсон үедээ байшин барьж, малаа хөлсөөр айлд тавьж, бүрэн суурьшилд шилжинэ. Энэхүү үйл явцыг Арвайхээр-Улаанбаатар-Чингис чиглэлийн улсын чанартай авто замын дагуух үйлчилгээний цэгүүдийн жишээгээр судалж үзэхэд 2017 онд нийт 24 үйлчилгээний цэгт 250 гаруй өрх, аж ахуйн нэгж суурьшин, үйл ажиллагаа явуулж (зураг 1) байгаа бөгөөд 40 хувь нь мал аж ахуй эрхэлж байна.



Зураг 1. Авто зам дагуух үйлчилгээний цэгүүдийн байршил
Эх сурвалж: Хээрийн судалгааны материал, 2016-2017

Монгол оронд нүүдэлч малчдын хот ба бусад суурин газар тийш тэмүүлсэн шилжих хөдөлгөөний хэлбэр хамгийн түгээмэл байна [Оюунгэрэл Ж., 2004]. Шилжигчдийн дийлэнх нь гэнэтийн үйл явдлаас бус эдийн засаг, гэр бүл, амьжиргаа, амьдралынхаа ахуй нөхцөлийг сайжруулах хүсэл тэмүүлэл, зорилгоос үүдэлтэйгээр шилжилт хөдөлгөөнд оролцоно.

Судалгаанд хамрагдсан сумын төвийн 200 өрхөөс 21.5 хувь нь (43 өрх) хөдөө нутгаас шилжиж ирсэн өрх байсан ба ажил олж хийх шаардлагаар 55.9 хувь, хот сууринд амьдардаг ах дүүгээ бараадах, тэдэнтэйгээ ойр

амьдрах зорилгоор 28 хувь, бусад шалтгаанаар 16.1 хувь нь шилжин иржээ (хүснэгт 4). Харин боловсролын үйлчилгээ авах гэсэн шалтгааныг хүмүүс дурдаагүй байна.

Хүснэгт 4. Шилжин ирэгчдийн шалтгаан

Шалтгаан	Өрхийн тоо	Эзлэх хувь
Ахуйн хэрэгцээний бараа бүтээгдэхүүнийг хямд үнээр авах	3	6.9
Томоохон хот суурин руу явахад ойр, зам дагуу оршдог	2	4.6
Ажил олж хийх	24	55.9
Хүүхдэдээ илүү сайн боловсрол олгох	0	0
Хамаатан садангаа бараадах	12	28.0

Бэлчээрийн нутаг бараадан малаа дагаж	2	4.6
Бүгд	43	100

Эх сурвалж: *Хээрийн судалгааны материал, 2016-2018*

Шилжих хөдөлгөөний урсгал нь тухайн орны эдийн засгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн бүтцээс шалтгаалан байнга өөрчлөгдөж [ҮСХ., 2011] байдаг ба энэ хэлбэр нь манай орны нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн ялгааг харуулж байна.

Дүгнэлт

Орчин үед нүүдлийн амьдралын хэв маягаас суурин амьдралын хэв маягт шилжих нь давамгайлах болжээ. 2016-2018 онд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 420 малчин өрхийн асуулгад боловсруулалт хийхэд 60 орчим хувь нь нүүдлээр аж төрж байгаа бол үлдсэн хувь нь хагас суурьшлыг бий болгож байна. Хагас суурьшлын 3 хэлбэрийг ялгасан ба уламжлалт нүүдлийн тоо, зай цөөрч, нэг буурин дээрээ удаан сууж буй малчдын хагас суурьшил, ямар нэгэн суурин газарт өрх тасран амьдарч буй малчдын хагас суурьшил, хот орчмын бүсэд мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын шинэ хэлбэрийг үүсгэн суурьшиж буй малчдын хагас суурьшил болно. Харин дэд бүтцийн сайтар хөгжилтэй суурин газарт суурьшиж, орлогын олон төрөлтэй болж буйгаар малчдын бүрэн суурьшил илэрч байна. Хөдөөгийн хүн ам бүрэн суурьшилд шилжиж буй 2 хэлбэр байна. Үүнд хатуу хучилттай авто зам дагуух зорчигчдод үйлчлэх үйлчилгээний цэгт болон хот суурин газарт шилжиж очиж, суурьшмал амьдралын хэв маяг руу шууд орж байна. Гэхдээ нутаг дэвсгэрийн ялгаа, байгалийн бүс бүслүүр, аж ахуй эрхлэлтийн онцлогоос хамааран

суурьшлын хэлбэрүүд өөр өөр байгаа нь ажиглагдаж байна.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг бичихэд үнэтэй зөвлөгөө өгсөн, түүвэр судалгаанд хамтран оролцсон "Хөдөөгийн хүн амын суурьших үйл явцын газарзүйн судалгаа" (2017-2019) суурь судалгааны төслийн багийн судлаач нартаа талархал илэрхийлье.

Ашигласан материал

- Базаргүр Д. 2005. "Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй". Улаанбаатар. х.202
- Базаргүр Д., Чинбат Б., Шийрэв-Адъяа С. 1990. "БНМАУ-ын малчдын нүүдэл". Улаанбаатар. х.26.
- Баянтөр М., Гантөмөр Х. 1971. "БНМАУ-ын хот суурингийн 50 жил дэх өсөлт ба хот байгууламжийн газарзүйн зарим асуудал", *Монгол Орны Газарзүйн Асуудал*, №11, Улаанбаатар. х.203.
- Гунгаадаш Б. 1986. "БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй". Улаанбаатар. х.201.
- Жагварал Н. 1974. "Аратство и аратское хозяйство". Уланбатор, ст.77.
- Лхагважав Н. 1979. "Бэлчээрийг хуваарьтай ашиглах арга". Улаанбаатар, х.50.
- Оюунгэрэл Ж. 2004. "Нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл дэх Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний газарзүйн асуудлууд". Улаанбаатар. х.16.
- ҮСХ. 2011. "Шилжих хөдөлгөөн ба суурьшил". *Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого*, Улаанбаатар, х.24.
- Цэцэнбилэг Ц., ба бусад. 2017. "Хөдөөгийн иргэдийн амьдралын хэв маяг: өөрчлөлт, хандлага". Суурь судалгааны төслийн тайлан. 2014-2016. Улаанбаатар, х.21.
- Шийрэв-Адъяа С. 1999. "Нүүдэлч малчдыг суурьшуулах газарзүйн зарим асуудал". Улаанбаатар. х.108.